



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/18

Номгон

「Хөдөө аж ахуйн кластер төслийн газар  
тариалан, малын тэжээлийн дэд төслийн ажлуудыг  
зохион байгуулж, 2024 оны батлагдсан төсөвт  
өртгийг хуваарилан зарцуулах тухай

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тус тус заасан "Тогтвортой хөдөө аж ахуй" зорилгын хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх, мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах цогцолбор байгуулах, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх замаар малын тэжээл, төмс, хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилгоор Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн XVI.1.21, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын "Аймаг орон нутагт эрх шилжүүлэх хуваарь батлах тухай" А-58 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтад батлагдсан 10 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий "Хөдөө аж ахуйн кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл"-ийн хүрээнд Хөдөө аж ахуйн кластерийн барилга, байгууламж, тариалангийн талбайн цахилгааны станц, дэд станц, хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, гадна тохижилт, хүрмэн бетон хашаа, хүлэмжийн ажлуудыг үргэлжлүүлэн зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.


2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн XVI.1.21 дугаарт батлагдсан "Хөдөө аж ахуйн кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл"-ийн энэ онд батлагдсан 5,930.6 сая төгрөгийг энэхүү захирамжийн хавсралтын дагуу хуваариар баталж төсөл, арга хэмжээг гүйцэтгэлээр олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

042311993

2.

3. "Хөдөө аж ахуйн кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл"-ийн батлагдсан ажлуудыг зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахыг орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын  
19-ний өдрийн д... дугаар захирамжийн  
хэвсрэг



ХӨДӨӨ АЖ АХУЙН КЛАСТЕР ТӨСЛИЙН ГАЗАР ТАРИАЛАН,  
МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН ДЭД ТӨСӨЛ БАЙГУУЛАХ  
ЖАГСААЛТ

Багц	Төслийн нэр	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Гэрээний дүн	Авсан санхүүжилт	Үлдэгдэл буюу 2024 онд санхүүжих дүн
1	ХААК барилга байгууламжийн ажил	2022	2024	4,315.07	1,490.0	2,825.1
3	Тариалангийн талбайн цахилгаан станц, дэд станцын ажил	2022	2024	191.31	91.3	100.01
4	ХАА машин тоног төхөөрөмж	2022	2024	2,835.20	992.2	1,843.0
5	ХАА гадна тохижилт хүрмэн бетон хашаа	2022	2024	1,173.96	974.0	199.96
6	Хүлэмжийн барилгын ажил	2022	2024	1,678.00	760.0	918.0
	НИЙТ			10,193.5	4,307.5	5,886.0